



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Төсөв батлах тухай” 03 дугаар тогтоолын дагуу тус сургуулийн албан хэрэгцээнд зориулан нийт 821,000,000.00 (найман зуун хорин нэгэн сая) төгрөгт багтаан хавсралтад заасан төсөл арга хэмжээг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх замаар үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн захирал Т.Хэрүүга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


А.АРИУНБОЛД

0000155

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн
.....44..... дугаар тогтоолын хавсралт



Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн 2019 онд хэрэгжүүлэх
төсөл, арга хэмжээний жагсаалт

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
		(мян.төгрөг)
	Барилга	
1	Эдийн засаг, бизнесийн сургуулийн номын сангийн барилгын санхүүжилт	175,000.0
	Тээврийн хэрэгсэл	
2	Бага оврын автобус 2 ширхэг, суудлын тоо 25, хөдөлгүүрийн багтаамж 3400 сс, улсын дугаар аваагүй	100,000.0
3	Сургалтын зориулалттай суудлын автомашин 3 ширхэг, суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 2400сс хүртэл, улсын дугаар аваагүй	38,000.0
4	Ачааны автомашин 1 ширхэг, 1.2 тонн, улсын дугаар аваагүй	10,000.0
5	Жижиг оврын трактор 1 ширхэг	25,000.0
6	Жижиг мотоцикл 1 ширхэг	3,000.0
	Бүгд дүн	176,000.0
	Биет бус хөрөнгө	
7	Юникус программ лиценз, UMLS систем төлбөр сургалтын программ	50,000.0
	Бүгд дүн	50,000.0
8	Тоног төхөөрөмжийн бүгд дүн	240,000.0
9	Тавилга эд хогшлын бүгд дүн	180,000.0
НИЙТ ДҮН		821,000.0
		(найман зуун хорин нэгэн сая)